

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.05.01

Бүгц	Дугаар	Агуулга	Шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
							Он	түвшин			
1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО											
Зорилго	1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.	Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 48,8 Хандив 12.7	2023	85	90	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөц" байвал зохих 46 нэр төрлийн эм, 39 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 11 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 6 нэр төрлийн тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн оношлуур, 7 нэр төрлийн ариутгал халдваргүйтгэлийн бодисыг бүрдүүлж гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж ажилласан. НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 3.4 сая төгрөгийн хоол тэжээл багц, Велл бии ХХК -аас 9.3 сая төгрөгийн иргэдийн дархлаажуулалт дэмжих эм бэлдмэлийн тус тус олгосон. Гамшгийн үеийн нөөцийн хангалт 90,2 хувьтай.	100
			Теле хичээл тогтмол судлан үзэж буй сурагчдын эзлэх хувь	хувь	2021-2024		2023	85	95	Цар тахлын нөхцөл байдал арилсантай холбогдуулан аймгийн 19 сургууль 100 хувь танхимаар хичээллэж теле хичээлийг судлах шаардлагагүй болсон бөгөөд мэргэжлийн багш нар теле хичээлийг сургалтын явцад хэрэглэдэггүй болгон ашиглаж, цахим хичээлийн сантай болсон нь үр дүнтэй байна.	
Зорилт	1.1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.	Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ	Сая.төг	2021-2024	ДЭМБ 74.4 УТХО 321.6 Хандив 527.1	2023	485.0	535.0	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 923.1 сая төгрөгийн санхүүжилт авсан.	100
Арга хэмжээ	1.1.1	Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх	Эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтын хувь	хувь	2021-2024		2023	83.9	90	2024 оны 10 дугаар сард хийгдэнэ.	ХБ
	1.1.2	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах	Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 3.5	2023	85	90	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 тушаалийн Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган амьсгалын аппарат, зөөврийн рентген аппарат, зөөврийн эхо аппарат, өвчтөний хяналтын монитор, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, пульсоксиметр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратын хэвийн ажиллагааг ханган ашиглаж байна. Тоног төхөөрөмжийн хангалт 90,7 хувьтай байна.	100
			Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024		2023	58	60	Эрүүл мэндийн байгууллагуудад эм эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байдалд үнэлгээ хийхэд гамшгийн үеийн нийт 107 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөц байхаас 93 төрөл, хангалт 86,9 хувьтай байна.	
1.1.3	Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах	Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо	тоо	2021-2024	УТХО 0.4	2023	55	55	Сурган дадлагажуулсан мэргэжлийн анги 2 байгаа ба тайлант хугацаанд Гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны штаб, мэргэжлийн ангийн 93 эмч мэргэжилтнүүд оролцсон байна.	100	
		Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн тоо бүрэлдэхүүний тоо	тоо	2021-2024		2023	2	2	Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнээс "Гамшгийн үеийн сэтгэц-нийгмийн дэмжлэг үзүүлэх" говийн бүсийн бүсчилсэн танхимын сургалтад 20, осголт, хөдөлтийн үед авах арга хэмжээ,угаарын хийн хордлогын үеийн эмнэлзүй, авах арга хэмжээ цахим сургалтад 45 эмч, мэргэжилтнийг сурган дадлагажуулсан.		

1.1.4	Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх	нэвтрүүлсэн сургуулийн тоо	тоо	2021-2024	УТ 33,0 сая	2023	6	8	Цахим шилжилт туршилтыг аймгийн 19 сургуульд нэвтрүүлэхээр гол дэд бүтэц болох интернэт сүлжээнд холбох, wifi төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажлыг 19 сургууль дээр хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд Хүмүүнлэг, Говийн Ирээдүй сургуулиуд орон нутгийн 260,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахим ангийн тендер зарлагдаад байна. 2023-2024 онд 17 сургууль тус бүр 15-20 сая төгрөгийн wifi, тоног төхөөрөмжийг суурилуулж, дотуур байр, хичээлийн байрны анги танхимд интернэтийг бүрэн тарааж, цахим ангиудад 394 ширхэг таблет, 172 ширхэг chromebook, 28 ширхэг ухаалаг самбар, 66 ширхэг ухаалаг телевиз зэрэг тоног төхөөрөмжийг байршуулж, цахим шилжилтийг нэвтрүүлэх боломжийг ханган ажиллалаа. 2023 оны 3 дугаар улиралд Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуульд Мобиком корпорацийн "SMART EDUCATION 3" төслийн хүрээнд төгрөгийн дижитал самбар, 25 ширхэг chromebook, виртуал орчинд хичээлээ үзэх боломжтой VR төхөөрөмж, өндөр хурдны интернэт, тухайн төхөөрөмжөөр үзэх хичээлийн контентууд бүхий иж бүрэн цахим анги 130,0 сая төгрөгийн хөрөнгөөр байгуулагдсан байна. Үүний үр дүнд eduten, reorson хөтөлбөрийн цахим хичээлүүд болон бусад цахим платформуыг сургалтад ашиглах, сургалтын чанарыг дээшлүүлэх нөхцөл бүрдээд байна.	100
1.1.5	Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах	зөөврийн компьютерээр хангагдсан багш нарын хувь	хувь	2021-2024	Төслөөс 47.0	2023	95	100	Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 95 хувь зөөврийн компьютероор хангагдсан. 2024 оны судалгаагаар яамны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Lenovo E40 хуучин зөөврийн компьютер 273 ширхэгийг багш нарын 51,6 хувь албан хэрэгцээндээ ашигладаг, шинээр нийлүүлэгдсэн зөөврийн компьютер болох 203 ширхэгийг нийт багш нарын 43,4 хувь албан хэрэгцээндээ ашиглаж байна. 2023 онд сургуулийн өмнөх боловсролд БШУЯ-наас 50 ширхэг зөөврийн компьютерээр хангаж, нийт багш нарын 50 хувь шинэ компьютероор хангагдсанаар сургуулийн өмнөх боловсролын багш нар 100 хувь хангагдсан. Хосолсон сургалтын арга зүйн сургалтад 3 сумын сургуулийн 9 багшид 47 сая төгрөгийн зөөврийн компьютер олгоод байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш нарын компьютерын хангалт 97,5 хувьтай байна.	100

2.1.1.3	Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах	Зорилтот бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалтын хувь	хувь	2021-2024	ЭМДСан 640.0	2023	51	54	Тайлант хугацаанд нийт 85 халдварт өвчин бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10000 хүнд амд 17.5-аар буурсан байна. Зорилтот бүлгийн иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр сүрьеэ 8, бэлгийн замаар халдварт өвчлөл 28 тохиолдол илрүүлж эмчийн хяналтад авсан. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 22795 иргэнээс 4391 буюу 19,3%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 24056 иргэнээс 4459 буюу 18,5%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2295 иргэн хамрагдахаас 539 буюу 23,5%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8043 иргэн хамрагдахаас 1270 буюу 15,8%-тай хамрагдсан байна. Зорилтот иргэдийн үзлэгт хамрагдалт 19.2% байгаа ба артерийн гипертензитэй 20, чихрийн шижинтэй 2 хүнийг илрүүлэн хяналтад авсан.	50
		Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 7.8	2023	33.8	34.0	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 47199 иргэн хамрагдахаас 20915 хамрагдаж, хамрагдалтын хувь 44.3% байна.	
2.1.1.4	Өвөр Монголын өөртөө засах орны уламжлалтын эмчилгээ, оношлогооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах.	Орон нутагт үзлэг зохион байгуулсан эсэх	Тийм 1, Үгүй 0	2023-2024		2023	1	1	2023 оны10 дугаар сарын 23 –ны 01/ 1340 дугаартай аймгийн засаг даргын албан бичгийг Өвөр Монголын өөртөө засах орны Баяннуур аймгийн Ардын засгийн ордонд явуулсан бөгөөд зөвшөөрөл олгогдоогүй гэдэг шалтгаанаар ирээгүй болно. Дахин Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02 –ны өдрийн 01/1385 албан бичгээр 2024 оны төлөвлөгөөнд оруулж хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлээд байна Хариу ирээгүй байна.	ХБ
		Үзлэг оношилгоо, эмчилгээ хийлгэсэн иргэдийн тоо	тоо	2023-2024		2023		3500		Хариу ирээгүй байна.
2.1.1.5	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх	Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь	хувь	2021-2024		2023	89.5	90	Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн зайлшгүй шаардлагатай болон амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэлд 44 багцийг "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах хууль"-ийн ийн дагуу тендер зарлан сонгон шалгаруулан худалдан авалт хийж хүртээмжийг нэмэгдүүлж байна. "Орион фарм эмийн программ"-ийг ашиглан эмийн чанар, аюулгүй байдлын дотоод хяналт хийсэн ба зайлшгүй шаардлагатай, амин чухал эмийн хангалт 89.6% байна.	99.7
		Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	86	88	Төлбөрийг төр хариуцах эмийн батлагдсан төсөв 24,591,800 төгрөг байна. Тайлант хугацаанд эмийн эмийн жороор 216 иргэнд 7 төрлийн оношоор 5,657428 төгрөгийн төлбөрийг нь төр хариуцах эмээр үйлчилсэн байна. Эмчийн жор бичилтээр олгогдсон эм 100% байна.	
Зорилт	2.1.2	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна.	Эхийн эндэгдэлийн түвшин	түвшин	2021-2024	УТХО 16.5	0	0	2024 оны эхний 4 сард нийт 201 эх төрж, амьд төрөлт 200 бүртгэгдсэн. Нийт төрсөн эхчүүдийн 95% аймгийн нэгдсэн эмнэлэгт амаржсан ба эхийн эндэгдэл гараагүй.	100
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/	промилль	2021-2024		10.3	9	Өнгөрсөн оны мөн үед 4.1 промилль байсан бөгөөд эхний 4 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.	

Арга хэмжээ	2.1.2.1	Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах	Эхчүүдийн амрах байраар амарсан эхийн тоо	тоо	2021-2024	УТХО 22.8	2023	285	300	Эхийн амрах байраар 16 эх амарч 80 ор хоног ашигласан байна. Нийт төрөлтөд эзлэх хувь 7.9. Амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах төслийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эмч нар боловсруулан сумын Засаг даргын Тамгын газарт орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр хургуулсан.	50
	2.1.2.2	0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх	Чийрэгжүүлэлтэд хамрагдсан хүүхдийн тоо	тоо	2021-2024	УТХО 5.3	2023	4	3	Эхний 4 сарын байдлаар 0-5 насны 4257 хүүхэд жинлэхээс 1938 хүүхэд буюу 45.5%-ийг жинлэсэн байна. Үүнээс туранхай 1, тураалтай 1 хүүхэд байсан ба эцэг эхэд хоол тэжээлийн зөвлөгөө өгч, багийн эмчийн хяналтад гэрээр хооллолт, чийрэгжүүлэлтэд хамруулж байна. Чийрэгжүүлэлтэд хамрагдаж буй хүүхэд 2 байна.	100
Зорилт	2.1.3	Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ.	Хэрэглэгчийн үнэлгээний хувь	хувь	2021-2024	УТХО 332.9 ЭМДС 4.363.3	2023	93.1	93.6	Эхний 4 сарын байдлаар 13.13.тп цахим хаягаар эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлж буй 960 иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авч дүгнэхэд эерэг үзүүлэлт 84.8% байна. Эмнэлгүүд QR код уншуулан хэрэглэгчийн үнэлгээ авах нөхцөлийг 100% бүрдүүлсэн.	0
Арга хэмжээ	2.1.3.1	Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологиор хангах	Мобайль технологиор хангагдсан сумын тоо	тоо	2021-2024	УТХО 15.2	2023	12	15	Тайлант хугацаанд Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төвд 15.2 сая төгрөгийн санхүүжилтээр Мобайль технологийг нийлүүлэн хүн амд үйлчилгээ үзүүлж байна. Мобайль технологиор хангагдсан сумын тоо 13 буюу 86.6% боллоо.	33
	2.1.3.2	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх	Нэр төрлийн тоо	тоо	2021-2024	ЭМДС 4363.3	2023	14	14	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд бүрэн шилжсэн ба ЭМД-ийн санхүүжилтээр 18 нэр төрлийн оношийн бүлэг заалтаар тусламж үйлчилгээ үзүүлж сар бүр санхүүжилтээ авч байна. Эхний 4 сарын байдлаар 4.396.0 санхүүжилт авахаас 4.363.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
			Санхүүжилтын гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	91.5	93	Гүйцэтгэлийн санхүүжилт 99.2 хувь	
	2.1.3.3	Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах	Яаралтай тусламжийн цэгийн тоо	тоо	2021-2024	УТХО 1.5	2023	5	6	Сайнцагаан сумын автозамын пост, Хулд, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо сумдад яаралтай тусламжийн 5 цэгийг байгуулан ажиллаж байна. 2024 оны 12 сард Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн "Яаралтай тусламжийн цэг"-ийг нээхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Цэгт шаардлагтай 6 нэр төрлийн 10 тоног төхөөрөмж мөн Сайхан-Овоо сумын цэгт нэмэлт тоног төхөөрөмж авахаар тендер шалгаруулалт зарлагдсан. Яаралтай тусламжийн цэгээр зам тээврийн осол 11, бусдад зодуулсан 5, уналт 10, осголт 1, түлэгдэлт 1, нохойд уруулсан 2 тохиолдолд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.	0
Арга хэмжээ	2.1.3.4	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 44.9	2023	47	48	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн болон гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор 6 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Яаралтай тоног төхөөрөмжийн хангалт 79.5 хувьтай байна.	100
			Тоноглогосон тоо	тоо	2021-2024	УТХО 40.0	2023	4	5	Өлзийт сумын эрүүл мэндийн төв 1 яаралтай тусламжийн тоноглогдсон машинаар хангагдан, аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 5 боллоо.	

			Машины хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 184.0	2023	94	95	Улсын төсвийн 184.0 сая төгрөгийн хөрөнгөөр Өлзийт, Говь-Угтаал сумын эрүүл мэндийн төвд 2 автомашиныг хүлээлгэн өгсөн. Түргэн тусламжийн автомашины хангалт 98% байна.	
	2.1.3.5	Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах	2 дагч шатлалын эмнэлгээс онлайнар зөвлөгөө авсан тоо	тоо	2021-2024	УТХО 2.1	2023	25	30	Төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс 5 удаа, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар 6 удаа зөвлөгөөг өгсөн. Төрлөөр нь авч үзвэл гэмтлийн үеийн тусламж үйлчилгээ, эмийн чанар аюулгүй байдал, олон улсын эмнэлзүйн программ ашиглах, хүүхэд, насанд хүрэгчдийн томуугийн эмчилгээ, гамшгийн үеийн сэтгэлзүйн тусламжийн чиглэлээр зөвлөгөө авсан байна. Тайлант хугацаанд Хоёрдогч шатлалын эмнэлгээс нийт 11 удаа зөвлөгөө авч эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлэн ажиллаж байна.	100
			Компьютерийн тоо	тоо	2021-2024	УТХО 9.3	2023	49	50	Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Адаацаг, Дэрэн, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд ЭМД-ийн гүйцэтгэлийн санхүүжилтээр албан хэрэгцээнд 4 компьютер авч цахимаар эмчилгээ үйлчилгээ, оношилгоо авах боломжийг бүрдүүллээ. Шинээр авсан компьютер 4 өссөн дүнгээр 53 боллоо.	
дэд зорилт	2.1.3.1	Эмнэлэгүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 222.0 Хандив 514.4 ОНХС 299.0	2023	86.0	86.7	Тайлант хугацаанд аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 19 нэр төрлийн 507.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1% байна.	100
	2.1.3.1.1	Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих	Тухайн жилд шинээр барьсан эмнэлгийн барилгын тоо	тоо	2021-2024	УТХО 520.0	2023	0	3	Улсын төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгөөр Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 сая төгрөг хөрөнгөөр 100 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод тохижилтийн ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажил хангагдсан. Өндөршил, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг хойшлогдсон.	ХБ
	2.1.3.1.2	Нэгдсэн эмнэлгийн амбулатори, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар, Боржигон мандал, Өлзийт мандал, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийх	Засвар хийгдсэн эмнэлгийн тоо	тоо	2021-2024	УТХО 28.9 Хандив 200.0	2023	6	6	Орон нутгийн хөгжлийн сангийн 185.0 сая төгрөгийн хөрөнгөөр Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төв, Адаацаг, Луус сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засвар хийгдэхээр бэлтгэж ажил хангагдсан. Дэлгэрцогт сумын эрүүл мэндийн төв "М-Си-Эс групп"-ын 200.0 сая төгрөгийн тусламжаар, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төвүүд ЭМД-ийн гүйцэтгэлийн санхүүжилт 28.9 сая төгрөгийн хөрөнгөөр засвар, үйлчилгээ хийсэн байна.Засвар хийсэн эмнэлгийн тоо 2 болж өссөн дүнгээр 6 боллоо.	50
			Өргөтгөл нийсэн эмнэлгийн тоо	тоо	2021-2024	ОНХС 299.0	2023	1	1	Боржигон мандал өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажил буулах хөрөнгө шийдэгдээгүй учраас 2025 онд гүйцэтгэхээр хойшлогдсон ба тайлант хугацаанд Орон нутгийн хөгжлийн сангийн 299.0 сая төгрөгийн хөрөнгөөр цэвэр, бохир ус, нийтийн халаалтад холбохоор зураг төслийн ажлыг хийж гүйцэтгүүлээ.	

Арга хэмжээ	2.1.3.1.3	Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах.	Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 24.5 Хандив 74.5	2023	79.0	80.0	Баянжаргалан, Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвүүд 15.5 сая төгрөгөөр ариутгалын ам наагч, 13 камер, гаднах талбайн гэрлэн хаяг, пректор зэрэг 8 төрлийн тоног төхөөрөмж, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг 9.0 сая төгрөгөөр 12 орыг ЭМД-ийн гүйцэтгэлийн санхүүжилтээр худалдан авч орчин нөхцөлөө сайжруулаа. ДЭМБ-аас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Өлзийт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад 13.0 сая төгрөгийн бүлээцүүлэх хөнжил, 7.8 сая төгрөгийн хэм хяналтын термостат, аймгийн хэмжээний нийт 68 багийн эмчид 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхийг хандивлан, хүлээлгэн өгсөн. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 89.1% байна.	100
			Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 168.1 Хандив 239.9	2023	93.0	93.5	Аймгийн нэгдсэн эмнэлэгт ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны төсөл"-ийн хүрээнд 137.6 сая төгрөгийн V7N маркын зүрхний ЭХО аппарат, 30.5 сая төгрөгийн ходоодны уян дуран, НҮБ-ын Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар 239.9 сая төгрөгийн STERIPPLUS-40 маркийн хог хаягдлын автоклавыг тус тус нийлүүлсэн ба нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 95.2% боллоо. ДЭМБ, АХБ-ны хөрөнгө оруулалтаар "Зооноз өвчин судлалын төв"-д PCR-ын шинжилгээний аппарат, дагалдах эм, урвалж бодис, био аюулгүй кабинет, лабораторийн ширээ, хөргөгч, хөлдөөгч зэрэг 8 төрлийн тоног төхөөрөмж олгож лабораторийн орчин нөхцөл болон чадавхийг сайжруулж орон нутагт шаардлагатай PCR-ийн шинжилгээг нэмэлтээр хийдэг болсон.	
	2.1.3.1.4	Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай ЭМБ-ын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 0.5	2023	84.2	85	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдээс 4 эрүүл мэндийн байгууллага шаардлага хангахгүй ариун байгууламжтай байгаа бөгөөд сайжруулах ажлын зураг төлийг, төсвийн хамт ЭМЯ-д хүргүүлээд байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь 86.6 байна.	100
Зорилт	2.1.4	Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд 97.5 хувьд хүргэнэ.	Хүний нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 78.8	2023	97.0	97.5	Эрүүл мэндийн салбарт 758 эмч эмнэлгийн мэргэжилтэн ажиллахаас 692 ажиллаж буюу хүний нөөцийн хангалт 91.2% байна.	70
Арга хэмжээ	2.1.4.1	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах	Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 36.0	2023	43	45	Эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчдын 43.3% гэр болон түрээсийн байранд амьдарч байна. Хулд сумын эрүүл мэндийн төвд шинээр ирсэн 1 эмчийг албаны байранд оруулж, тогтвортой ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Орон сууцаар хангагдсан албан хаагчийн эзлэх хувь 56.7 байна.	100
			Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 12.5	2023	95	96.9	Нэгдсэн эмнэлэгт хавдрын хими эмчилгээ, нярай, компьютер томографиаар, эмнэл зүйн эм зүй, эх барих, эмэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо, хавдрын хими эмчилгээ чиглэлээр 6 эмчийг мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулж байна.Нарийн мэргэжлийн эмчийн хангалт 97% хүрсэн.	

	2.1.4.2	Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх.	мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо	тоо	2021-2024	УТХО 20.0	2023	33	43	Гурвансайхан, Дэрэн сумын эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг дархлаажуулалт, гэр бүл төлөвлөлт, эх барих, яаралтай тусламж, хүүхэд, компьютер томограф, рентген зэрэг 8 төрлөөр, Говь-Угтаал, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төвүүд бүртгэл мэдээллийн ажилтан, мэс заслын сувилагч зэрэг 2 төрлөөр эмч эмнэлгийн ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. Тайлант хугацаанд нийт 8 сувилагч, тусгай мэргэжилтэн бэлтгэгдэж өссөн дүнгээр 41 боллоо.	97.6
дэд арга хэмжээ	2.1.4.2.1	Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх	Сувилагч мэргэжилтний хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 2.3	2023	86.7	87.0	Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төвийн удирдлагууд АШУУИС-ийн харъяа "Дорноговь аймаг дахь салбар сургууль"-ийн төгсөх курсын оюутнууд болон одоо суралцаж буй орон нутгийн 19 оюутантай уулзан цаашид орон нутгийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, элсэлтийн үйл ажиллагаанд дамжлаг үзүүлэх, сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгууллаа. Энэ оны 6 сарын төгсөлтөөр 4 оюутныг аймагт ажиллуулах асуудлыг шийдвэрлэсэн үр дүнтэй байлаа. Сувилагчийн хангалт 87.2% байна.	100
	2.1.4.2.2	"Ахмадын ордон", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-д ахмад настууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх	Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн тоо	тоо	2021-2024		2023	2	4	2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв шинээр ашиглалтад орж, 4 их эмч, 2 сэргээн засалч, техникч 1-ыг мэргэшүүлэн сургалтад хамрагдан ажиллаж байна. Ахмадын ордонд аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын эмч давхар хариуцан ажиллаж байна. Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөц 7 байна.	100
Арга хэмжээ	2.1.4.3	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, сургалтад хамруулах	Гадаад сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	тоо	2022-2024	УТХО 8.0	2023	69	79	Эрүүл мэндийн газрын дарга Бүгд Найрамдах Солонгос, Япон улсад, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Бүгд Найрамдах Солонгос улсад удирдлагын чиглэлээр, Индонез, Хөх хотод болсон олон улсын бага хуралд аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний эмчийг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын эмчийг Банконт улсад тус тус сургалтад хамрууллаа. 2024 оны эхний 4 сарын байдлаар гадаад сургалтад нийт 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан ба өссөн дүнгээр 75 боллоо.	94.9
2.2. Биеийн тамир, спорт											
Зорилго	2.2	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 1835-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай байсныг 2024 онд 33.9 хувьд хүргэнэ.	Сорилд нийт хамрагдагчдын тоо	тоо	2021-2024		2023	4739	5200	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигын дагуу Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2774 иргэнийг түвшин тогтоох сорилд хамруулаад байна.	60
			Сорилд хамрагдагчдын А, В үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь	Хувь	2021-2024		2023	30.9	33.9	Сорилд 2774 хүн хамрагдсанаас 8.9% А үнэлгээтэй, 21.1% В үнэлгээтэй үнэлэгдсэн байна. Сорилд хамрагдагчдын 30% нь А, В үнэлгээтэй байна.	

Зорилт	2.2.1	Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2024 онд 28105-д хүргэнэ.	Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо	тоо	2021-2024	УТ- 500.0	2023	27377	28105	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан " Эрүүл мэндийн цахим гүйлт, "Дасгал Хөдөлгөөн хийцгээе", "Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих" сарын аян, "Энэ жилдээ - Эрүүл жиндээ", "Нэг анги нэг өглөө", "Цаг гаргая", "Илүүдэл жингүй Эртэч монгол", "Бүжгээр эрүүлжье", "Жин хасах" 2 сарын аян, "Эрүүл-Монгол", "Эрүүл чийрэг Дундговчууд" аян, "Мандалговь бүх нийтийн" кросс зэрэг нийтийн 13 төрлийн арга хэмжээнд 25295 иргэн хамрагдаад байна.	70
Арга хэмжээ	2.2.1.1	Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх	Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн тоо	Тоо	2021-2024		2023	11285	12340	Албан байгууллага, сум, аж ауйн нэгж, багийн иргэд, клубууд өглөөний дасгал, бүжгээр, фитнес, иог, спиннинг, алхалт, дугуй, явган аялал, цас, мөсний арга хэмжээ, зөөлөн гүйлтээр 8638 иргэн тогтмол хичээллэж байна.	50
дэд арга хэмжээ	2.2.1.1.1	Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх	Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Тоо	2021-2024	УТ-18.5	2023	15	16	Аймаг, улсын нийт 17 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан улсын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулсан. Мөн улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох эрхийн төлбөр, байр, хоол, унааны зардал, бэлтгэл, сургалт явуулах заал танхимаар ханган үйл ажиллагаанд нь 18.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
			Спорт хамтлагуудтай хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	тоо	2021-2024		2023	35	38	Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 39 байгууллагын спорт хамтлагтай хамтран, "Илүүдэл жингүй эртэч монгол" аян, бие бялдрын түвшин тогтоох сорил, салбарын нэрэмжит тэмцээн уралдаан зэрэг нийт 35 арга хэмжээнд 41 албан байгууллагын давхардсан тоогоор 3500 иргэнийг хамруулж оролцуулсан.	92
	2.2.1.1.4	Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион байгуулах	Наран Хөгцтийн шагайн харвааны наадамд оролцсон багийн тоо	тоо	2021-2024		2023	36	38	2023 оны 08 дугаар сард Дэрэн сумын нутагт шагайн харвааны холбоотой хамтран Наран хөгцтийн шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд хурууний 15 багийн 120 харваач, чавхний 7 багийн 56 харваач нийт 22 багийн 176 харваач оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдсөн.	100
	2.2.1.1.5	Сагсан бөмбөгийн 3x3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлэх	3x3 спортын төрлөөр хичээллэгчдийн тоо 3x3 спортын багш, дасгалжуулагч, шүүгчээр бэлтгэгдсэн хүний тоо	тоо тоо	2021-2024 2021-2024	УТ 600.0	2023 2023	4900 24	5200 26	Аймгийн хэмжээнд нийт 15 сумын 5200 иргэн 3x3 сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна. Сургуулийн биеийн тамирын багш болон клубийн дасгалжуулагч зэрэг нийт 25 багш дасгалжуулагчид сургалт зохион байгуулж, 3x3 спортын шүүгчээр бэлтгэсэн.	100 96
Арга хэмжээ	2.2.1.3	Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах	Спортын цогцолборын гүйцэтгэлийн хувь	хувь	2023-2024	УТ 4082.0	2023	30	70	Усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг 2023 онд улсын төсвийн дөрвөн тэрбум наян хоёр /4.82.0/ сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг "Жи жи ай" ХХКомпани нэг давхрын карказ, суурийн дүүргэлт зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл 80 хувьтай, нийт барилгын гүйцэтгэлийн ажил 70 хувьд хүрсэн байна.	70
2.3 . Боловсрол											
Зорилго	2.3.	Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ.	Боловсролын чанарын үнэлгээний хувь	хувь	2021-2024		2023	44	47		ХБ

Зорилт	2.3.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2024 онд 76 хувьд хүргэнэ.	СӨБ-ын хамран сургалтын хувь	хувь	2021-2024		2023	75	76	Сургуулийн өмнөх боловсролд 4365 хүүхэд хамрагдахаас 3540 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 81.1 хувьтай байна. Энэ нь өмнөх оноос 3,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
Арга хэмжээ	2.3.1.1	Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр цэцэрлэгийн барилга барих	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024	УТ 2100.0 ОНТ 50.0	2023	80	50	Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг, Дэлгэрцогт сумын цэцэрлэгүүдийг 2023 оны 12 сард хүлээн авч ашиглалтад авсан бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 сарын 16-ны өдрийн 798-р тогтоолын дагуу 2024 онд аймгийн иргэдийн хурлын шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан. Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилга 2024-2025 онуудад баригдахаар улсын төсөвт тусгагдан барилгын ажил эхлээд 30%-тай явагдаж байна. Хулд сумын цэцэрлэгийн барилгын зураг төсөв хийгдэж магадлалын дүгнэлт гарсан бөгөөд 2025 оны төсөвт суулгуулахаар "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулсан. Цагаандэлгэр сумын цэцэрлэгийн барилгын зураг төсвийг хийлгэхээр сумын орон нутгийн хөгжлийн санд 50.0 сая төгрөг суулгасан.	30
			Хөрөнгө шийдвэрлэсэн барилгын тоо	тоо	2021-2024		2023	2	4	Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын ажлын нийт төсөв 3.3 тэрбум төгрөг бөгөөд энэ онд 2,061.50 сая төгрөг төсөвт суугдан барилгын ажил эхлээд явж байна.	50
	2.3.1.2	Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургана.	хөгжим тоглож сурсан бүлгийн багшийн эзлэх хувь	хувь	2021-2024		2023	50	60	2023-2024 оны хичээлийн жилд 22 цэцэрлэгийн нийт 112 багшаас даралтад хөгжим-65, чулуун хөгжим-3, үндэсний хөгжим-10, утсан хөгжим-14, үкүлэлэ-16 багш тоглож сурсан ба энэ нь нийт 68 багш буюу нийт багшийн 60.7 хувь нь 5 төрлийн хөгжмийг сурч хөгжим тоглох ур чадвараа хөгжүүлсэн.	100
	2.3.1.3	СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Хөгжим болон биеийн тамирын хичээлийн кабинетын тоо	тоо	2021-2024		2023	17	22	2023-2024 оны хичээлийн жилд аймгийн 22 цэцэрлэгийн дуу хөгжим, биеийн тамирын кабинетад шаардлагатай 9 төрлийн тоног төхөөрөмж Үүнд: Даралтад пианика хөгжим-105, толгойн микрофон-15, иж бүрэн зөөврийн чанга яригч-6, Авирдаг модон шат-1, Биеийн тамирын ком-14, матрасс-30, нуман шат-2, зөөлөн гар бөмбөг-30 ширхэгийг орон нутгийн хөрөнгөөр нийлүүлэгдэж дуу хөгжмийн 18, биеийн тамирын 4 кабинетыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан үр дүнтэй ажил боллоо.	100
Зорилт	2.3.2	ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь байсныг 2024 онд 96.5 хувьд хүргэнэ.	Бага, суурь боловсролын хамран сургалтын хувь	Хувь	2021-2024		2023	95.5	96.5	Бага, суурь боловсролын хамран сургалт 96,2 хувьтай. Ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 8852 хүүхэд хамрагдаж байна. Өөрийн аймгийн ЕБС-д 6-14 насны 7529 сурагч хамрагдаж Политехникийн коллеж болон насан туршийн боловсролоор, өөр аймгийн сургуульд хамрагдаж байгаа 6-14 насны 416 хүүхэд хамрагдаж байна. Нийт 6-14 насны 8296 хүүхэд хамрагдахаас 7945 хүүхэд хамрагдаж хамран сургалтын хувь 96,2 хувь байна. Энэ нь өмнөх оноос 1,1 хувиар өссөн байна.	100

	2.3.2.1	Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумдад шинээр сургуулийн барилга барих	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	50	80	Говийн Ирээдүй, Хүмүүнлэг сургуулиудын барилгын ажил 5 дугаар сарын 1-ны өдрөөс үргэлжлэн явагдаж байна. Говийн ирээдүй сургуулийн 1,2,3 давхрын шатны хонгил болон шалны ажил, дотор шаврын ажил хийгдэж байна. Хэрэгжилт 85%. Хүмүүнлэг сургуулийн хувьд гадна болон дотор бохирын шугам, дотор магистрал шугамууд бүрэн хийгдсэн, 1-р давхрын дотор шавар, гадна талын засадны рам хийгдэж байна. Хэрэгжилт 60%. Эрдэнэдалай сумын сургуулийн ажлын зураг төсөв магадлалаар баталгаажих шатандаа явж байна.	40
			Хөрөнгө шийдвэрлэсэн барилгын тоо	тоо	2021-2024		2023	2	1	Энэ онд Говийн ирээдүй сургууль 4.5 тэрбум, Хүмүүнлэг сургууль 7.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэнэ.	
Арга хэмжээ	2.3.2.1.1	Сайнцагаан сумын ЕБС-ийг түшиглэн олон улсын жишигт нийцсэн ЕБС-ийг байгуулах	Олон улсын жишигт нийцсэн ЕБС-ийг байгуулсан эсэх	тийм-1 үгүй-0	2024		2023		1		ХБ
	2.3.2.1.2.	Хулд сумын ЕБС-ийн барилгын их засварын ажлыг хийх	Засвар хийгдсэн эсэх	тийм-1 үгүй-0	2024	ОНТ 6.9	2023		1	2023 оны 12 дугаар сард ОНХС-аар Хулд сумын ЕБС-ийн барилгын их засварын ажлын зураг төсөв хийгдсэн	0
дэд арга хэмжээ	2.3.2.2	Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад шинээр дотуур байрны барилга барих	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	70	50	Говь-Угтаал сумын дотуур байрны ажил 4-р сарын 15-наас эхэлсэн. Гадна шавар, дээврийн ажил хийгдэж байна. Хэрэгжилт 50%. Адаацаг сумын байр зураг төсөв хийгдсэн. Ирэх оны төсөвт суулгуулахаар иргэдийн санал авч "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулсан. Дэлгэрхангай сумын дотуур байрыг шинээр барихыг өөрчилж их засвар хийхээр төлөвлөсөн бөгөөд аймаг болон сумын хөрөнгө оруулалтаар нийт 190.0 сая төгрөгийн санхүүжилттэй.	50
			Хөрөнгө шийдвэрлэсэн барилгын тоо	тоо	2021-2024	УТ 1.2 тэрбум	2023	1	2	Энэ онд Говь-угтаал сумын дотуур байр 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж барилгын ажил дуусна.	
арга хэмжээ	2.3.2.3	Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх	Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо	тоо	2022-2024	УТ 10.0 сая	2023	2	2	2024 онд ОХУ-руу 6 багш мэргэжил дээшлүүлэх сургалтад явж туршлага судалж ирсэн ба 2-р сард БНСУ-ын Чэжү Ду арал руу Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах тухай вакумжуулсан анхны монголын Англи хэлний Воркшоф программын сургалтад Эрдэнэдалай сумын Англи хэлний багш Ч.Уртнасан, Э.Батчимэг, Говийн Ирээдүй Цогцолбор сургуулийн багш Э.Ууганцэцэг, Эрдмийн Далай цогцолбор сургуулийн багш Б. Бат-Оюун нар аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, ЕБС-ийн дэмжлэгтэйгээр явж суралцан аймгийн хэмжээний бүх гадаад хэлний багш нарт сургалт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газрын санаачлагаар АЗДҮАХ-т багтсан чиглэлийн дагуу одоо Хэлло Ворлд олон Улсын хөтөлбөрт инкуйари хийж хэрэгжүүлж эхлээд байна. Хагас жилийн байдлаар 9 багш гадаадад мэргэжил дээшлүүлсэн.	100
	2.3.2.3.1	Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх	гэрээ байгуулсан оюутны тоо	тоо	2021-2024		2023	6	8		ХБ

	2.3.2.4	Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулах	10 судлагдахууны аймгийн дундаж оноо	оноо	2021-2024	2023	504	506		ХБ
дэд арга хэмжээ	2.3.2.4.1	Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь зөвлөх багийн үйлчилгээнд хамруулах	бага боловсролын багш нарын хамрагдалтын хувь	хувь	2021-2024	2023	90	100	БШУГ-ын Даргын баталсан удирдамжийн дагуу 5 сард "Зөвлөн туслах" 24 хүний бүрэлдэхүүнтэй баг 4 чиглэлд ажиллаж байна. Хэрэгжилт гарах болоогүй Багш нарыг багаар нь урамшуулах журмыг өргөжүүлэн сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын багш нарыг багаар нь урамшуулах журмыг батлаад байна.	90
			суурь боловсролын багш нарын хамрагдалтын хувь	хувь	2021-2024	2023	90	100	БШУГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 5 сард "Зөвлөн туслах" 24 хүний бүрэлдэхүүнтэй баг 4 чиглэлд ажиллаж байна.	
дэд арга хэмжээ	2.3.2.5	Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024	2023	80	85	2024 онд 4 багш, 4 суралцагч улсыг олимпиадад 2, 3-р байруудыг эзэлсэн. Мөн улсын багш нарын эрдэм шинжилгээний бага хуралд 2024 онд Сургуулийн өмнөх боловсролын илтгэлийн уралдаанд Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч Г.Мөнхтуяа, арга зүйч Энх-Эрдэнэ нар 3-р байр, ЕБС-ийн илтгэлийн уралдаанд Мандал сургуулийн М.Энхбаяр захиралтай удирдлагын баг тусгай байр тус тус эзэлсэн нь аймгийн багш нарын илтгэх болон судалгаа хийх чадвар тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ахиц гарсныг харуулж байна.	100
	2.3.2.5.1	СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоодод туршлага судлуулах	Тухайн жилд туршлага судалсан багшийн тоо	тоо	2021-2024	2023	60	60		ХБ
Арга хэмжээ	2.3.2.5.2	ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Хөгжмийн хичээлийн кабинетын тоо	тоо	2021-2024	2023	15	19	Энэ хичээлийн жилд 19 сургуулийн хөгжмийн хичээлийн кабинетад 378,3 сая төг-ийн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн нийлэгдэж сурагчдын авъяас чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн бөгөөд өмнөх онуудад кабинетын гэрчилгээтэй 2 сургууль байсан бол энэ хичээлийн жилд 13 сургууль хөгжмийн кабинет шинээр байгуулан гэрчилгээжүүлж аймгийн хэмжээнд нийт 15 сургууль хөгжмийн кабинетыг хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Шинээр өгсөн хэрэглэгдэхүүнийг ашиглан гитарын сургалтыг сурагчдын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан өнгөрсөн хичээлийн жилээс тогтмол зохион байгуулж байна.	0
			Биеийн тамирын хичээлийн кабинетын тоо	тоо	2021-2024	2023	15	19	Ерөнхий боловсролын 19 сургууль хичээл практикийн зардлаас 245,0 сая төгрөгийг биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнд зарцуулсан байна. Биеийн тамирын зааландаа засвар үйлчилгээ хийсэн Баянжаргалан, Говийн ирээдүй цогцолбор сургуулийн бага сургууль байна. Кабинетын шаардлага хангасан 15 кабинет ажиллаж байна. Адаацаг сумын ЕБС спорт заал шинээр ашиглалтад орсон. 2023-2024 оны хичээлийн жилд 7 нэмэгдсэн.	

	2.3.2.6	Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан суралцагч, иргэд, эцэг эхийн хувь	хувь	2021-2024		2023	38	40	2023-2024 онд давхардсан тоогоор 1545 сурагчдад албан байгууллагуудтай хамтран зохион байгуулж хамрагдах ёстой сурагчдыг 100% хамруулсан. Боловсрол нөхөн олгох сургалтад 2024 онд 22 хүүхэд суралцаж сургалтад хамрагдах ёстой сурагчдын тоо 100 хувь буюу бүрэн хамрагдсанаар сургалтын явцын үр дүн гарч байна. НТБТөв, сумдын нэгжийн багш нар амьдрах ухааны 8 чиглэлээр 2023-2024 онд 254 сургалтыг 40,950 иргэнд зохион байгууллаа. Үүнээс НТБТөв аймгийн төвийн болон сумдын сургууль, цэцэрлэгийн нийт 165, аймгийн Орон нутгийн музейн 10, аймгийн УЦУОШТөвийн 43 багш нийт 218 багш, ажилтанд амьдрах ухааны сургалт зохион байгуулсан.	100
	2.3.2.7	Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах	Танхимын тоо	тоо	2021-2024	269.8 сая Төсөл-159.8 сая УТ-60.7 сая ОНТ-20.0 сая	2023	9	13	2024 оны хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг Эрдмийн далай, Говийн ирээдүй, Цэцбиллиг, Мандал, Сайхан-Овоо, Дэлгэрцогт, Луус, Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай, Баянжаргалан, Гурвансайхан, сумын ерөнхий боловсролын сургуулиудад улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр байгууллаа. Нийт 12 сургууль буюу 63 хувь нь хөгжлийн танхимыг байгуулж, сурагчдын бэрхшээлийн онцлог, суралцах хэв маягт тохируулан ажиллаж, алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд нь сэргээн, хөгжүүлж байна.	100
Арга хэмжээ	2.3.2.8	Сургууль бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах	Байгуулсан кабинетын тоо	тоо	2021-2024	Хандив 130,0 сая ОНТ 10,3 сая Хандив 198,0	2023	16	26	2023-2024 оны хичээлийн жилд байгалийн ухааны 3 кабинетийг гэрчилгээжүүлээд байна. Эрдэнэдалай сум Мобиком корпорацийн "SMART EDUCATION 3" төслийн хүрээнд "Тэгш хүртээмжтэй боловсролыг хүүхэд бүрд хүргэх" зорилготой байгалийн ухааны 120 сая төгрөгийн өртөгтэй Дижитал ангитай болж хичээл сургалтаа тохилог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан ангид хичээллэхэд бэлэн боллоо. Мөн Сайхан овоо сумын сургууль орон нутгийн санхүүжилтээр байгалийн ухааны иж бүрэн кабинетыг ашиглалтанд оруулж, Цагаандэлгэр, Хулд сумын сургууль "Аргун-Публишин" ХХК-аас 9.5 сая төгрөгийн өртөг бүхий байгалийн ухааны виртуал кабинеттай болж аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар өмнөх 2 жилд байгуулсан бага ангийн 11, суурийн 2 байгалийн ухааны кабинеттай нийт 17 кабинеттай болж хичээл сургалтыг үр дүнтэй явуулах боломж бүрдээд байна. Мөн 2023-2024 оны эхний хагас жилийн байдлаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс Өлзийт, Говь угтаал, гурвансайхан сумдын сургуулиуд Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд: Германы зээлийн банк (KfW)-ны хөрөнгө оруулалтаар Байгаль орчин аялал, жуулчлалын яаманд хэрэгжиж буй "Биологийн олон янзын байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III" төслөөс тус бүр 66 сая төгрөгийн өртөг бүхий кабинетийг байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 20 кабинет хичээл сургалтыг үр дүнтэй явуулах боломж бүрдээд байна.	70

2.3.2.9	Сургууль, дотуур байрыг 100% шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох	Дотор нойлтой сургуулийн тоо	тоо	2021-2024	УТ 2,8 тэрбум	2023	17	19	2023-2024 хичээлийн жилд Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Өндөршил, Хулд, Дэрэн сумын сургуулийн 4 объект, дотуур байрын 4 объект, цэцэрлэгийн 4 объект нийт 12 объектод ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулан ашиглалтад оруулсан байна.	ХБ	
		Дотор нойлтой дотуур байрны тоо	тоо	2021-2024		2023	16	18	2023-2024 хичээлийн жилд Адаацаг, Өндөршил, Хулд, Дэрэн сумын сургуулийн дотуур байрын 4 объектод ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулан ашиглалтад оруулснаар нийт 16 дотуур байрны 14 буюу 87 хувь нь усанд орох нөхцөл бүрдсэн.		
		Усанд орох нөхцөл бүрдсэн дотуур байрны тоо	тоо	2021-2024		2023	17	18	2023-2024 хичээлийн жилд Адаацаг, Өндөршил, Хулд, Дэрэн сумын сургуулийн дотуур байрын 4 объектод ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулан ашиглалтад оруулснаар нийт 16 дотуур байрны 14 буюу 87 хувь нь усанд орох нөхцөл бүрдсэн.		
2.3.2.10	Цэцэрлэг, сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах	камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь	хувь	2021-2024		2023	80	90	Сургуулийн 19 сургуулийн 26 хичээлийн байранд нийт 494 камер суурилагдсан камержилт 100 хувь, 22 цэцэрлэгийн камержилт 100 хувь, Камер шинэчлэх сайжруулах шаардлагатай-1 цэцэрлэг, 1 дотуур байр байна.	100	
Зорилт	2.3.3	МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ.	Ажил эрхлэлтийн хувь	хувь	2021-2024		2023	69	70		ХБ
	2.3.3.1	Багшлах бүрэлдэхүүний боловсролын зэргийг ахиулан магистрын сургалтад хамруулах	Магистрын зэрэгтэй багшийн тоо	тоо	2021-2024	Хувийн хэвшил 6.0 сая	2023	19	21	Дундговь аймаг дахь Политехник коллеж нь 2023 оны 10-р сараас магистр зэрэгтэй 18 багштай бөгөөд одоо 3 багш магистрын хөтөлбөрт хамрагдаж байна.	100
2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал											
Зорилго	2.4	Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 74.8 хувь байсныг 2024 онд 77.2 хувьд хүргэнэ.	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	2021-2024		2023	76.6	77.2	2023 оны 4 улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 69,7 хувьтай гарсан бөгөөд Үндэсний статистикийн хорооноос 2024 оны 1 улирлын түвшин бодогдож гараагүй байна.	ХБ
	2.4.1	Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2024 онд 12218-д хүргэнэ	Нийгмийн даатгалд даатгуулсан иргэдийн тоо	тоо	2021-2024		2023	11888	12118	Нийгмийн даатгалын системийн хэмжээнд 2024 оныг Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх жил болгон зарлаж тус ажлын хүрээнд нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж малчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг 3000 иргэдэд сурталчлан ажилласны үр дүнд 12543 даатгуулагч хамрагдаж үүнээс заавал даатгуулагч 7160, сайн дурын 2250, эрүүл мэндийн даатгалд 3133 иргэн хамруулсан байна.	100

	2.4.1.1	Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Иргэдэд үзүүлсэн байх үйлчилгээний тоо	тоо	2021-2024		2023	8	9	Тэтгэмжийн даатгалын сангаас олгож байгаа 4 төрлийн тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 4 үйлчилгээ нийгмийн даатгалын лавлагаа мэдээлэлтэй холбоотой 6 үйлчилгээ, нийт 14 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлэн иргэд даатгуулагч нарт үйлчилгээ үзүүлж байна. 2021 онд 5 нэр төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байсан бол 2024 онд 14 нэр төрлийн цахим үйлчилгээгээр иргэд даатгуулагч нарт үйлчилж байна.	100
	2.4.1.2	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлэх	Цахимаар үйлчилгээ авч байгаа иргэдийн хувь	хувь	2021-2024		2023	30	35	2024 онд нийгмийн даатгалын цахим үйлчилгээнд 8526 тэтгэвэр авагч, 7160 заавал даатгуулагч, 117 хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 171 жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авагч, 78 оршуулгын тэтгэмж, 103 ажилгүйдлийн тэтгэмж, 2250 сайн дурын даатгуулагч нийт 14 нэр төрлийн цахим үйлчилгээгээр 18405 даатгуулагч иргэн үйлчлүүлснээр нийгмийн даатгалын үйлчилгээ авсан иргэдийн 85.9% хувь цахимаар үйлчилгээ авсан байна. Өнгөрсөн 2023 оноос 28,19 хувиар өссөн байна.	100
Зорилт	2.4.2	2019 оны байдлаар ажиллаж байгаа 22040 иргэний ажлын байрыг 2200 -аар нэмэгдүүлнэ.	Тухайн жилд ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	тоо	2021-2024		2023	667	773	Байнгын ажлын байранд 121, түр ажлын байранд 161 иргэнийг ажилд зуучилж, нийт 282 иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдсан байна. Байнгын ажлын байрыг ажил мэргэжлээр ангилан авч үзвэл: Менежер- 4 Мэргэжилтэн-66 Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн - 10 Контор, үйлчилгээний ажил- 5 Худалдаа, үйлчилгээний ажилтан-13 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан-1 Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил - 3 Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч -6 Энгийн ажил, мэргэжил – 13 байна.	ХБ
Арга хэмжээ	2.4.2.1	Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байранд зуучилж, бүртгэлжүүлэн, ажлын байртай болгох	Тухайн жилд байнгын ажлын байраар хангагдсан хүний тоо	тоо	2021-2024		2023	115	120	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв 4 дүгээр сард батлагдаж ирсний дагуу хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг иргэдэд цахимаар болон биечлэн хүргэж, санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хүлээн авч, эхний ээлжид ахмадын санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөгдсөн.	ХБ
	2.4.2.2	310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	Тухайн жилд ажлын байранд зуучилсан иргэний тоо	тоо	2021-2024		2023	52	53	2024 онд 310 ба түүнээс доош оноотой хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 287 өрхийн 18-аас дээш насны 746 иргэн байгаагаас, 131 иргэн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн байна. 5 сарын байдлаар байнгын ажлын байранд-4, түр болон улирлын чанартай ажилд-22, нийтийг хамарсан ажилд-41, нийт 67 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан байна.	100

	2.4.2.3	Түр ажлын байранд иргэдийг зуучилж ажлын байртай болгох	Тухайн жилд ажлын байранд зуучилсан иргэний тоо	тоо	2021-2024		2023	500	600	2024 оны 4 сарын байдлаар малын сэг зэм устгах ажилд 161 иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангаад байна.	32.2
Зорилт	2.4.3	Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага 2019 онд 24 байсныг 2024 онд 36-д хүргэнэ.	Ахмадад ээлтэй сум, баг, байгууллагын тоо	тоо	2021-2024		2023	33	36	Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний А/90 тоот захирамжаар батлагдсан "Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага шалгаруулах журам"-ын дагуу болзол хангасан Өндөршил сумын Соёлын төв, Цагдаагийн газар, Эрдэнэдалай сумын ЕБС, Өнгөт баг, Сайнцагаан сумын Далай багийг шалгаруулж "Ахмадад ээлтэй" сум, баг, байгууллага өргөмжлөл гардуулан хүндэтгэл үзүүлсэн. Аймгийн хэмжээнд 43 сум, баг, байгууллага шалгараад байна.	100
	2.4.3.1	Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд тогтмол хамруулах	Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ оношилгоонд хамрагдсан ахмад настны эзлэх хувь	хувь	2021-2024		2023	50	60	2024 оны эхний байдлаар Нэгдсэн эмнэлэгийн ахмадын кабинетаар 1553 ахмад, сумдын ЭМТ-өөр 2037 ахмад нийт 3590 ахмад ахмадуудын 60.3 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдсан байна.	100
	2.4.3.2	Ахмад настнуудыг нас,бие бялдарынх нь онцлог тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах	Алхалт, дасгал хөдөлгөөнд хамрагдсан ахмад настны тоо	тоо	2021-2024	ОНТ 4.55	2023	1385	1425	Ахмад настнуудыг бие бялдрынх онцлогт тохирсон дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цэнгээнт бүжгийн сургалт, Энэ жилдээ эрүүл жиндээ аян болон ахмад настны дасгал хөдөлгөөний талбайтай болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд 1381 ахмад алхалт, дасгал хөдөлгөөнд тогтмол хамрагдаж 21 ахмад унадаг дугуйгаар тогтмол хичээллэж, цэнгээнт бүжгийн сургалтад 161 ахмад хамрагдаж байна. Аймагт ахмадын цэнгээнт бүжгийн 1, шугаман бүжгийн 2 клуб тогтмол үйл ажиллагаа явуулж улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан. "Говийн донж" ахмадын цэнгээнт бүжгийн хамтлаг Баянхонгор аймагт зохион байгуулсан улсын уралдаанд 2-р байр, "Говийн наран" шугаман бүжгийн хамтлаг улсын уралдаанд 65 багаас 2-р байрт шалгарсан байна. Тус улсын чанартай уралдаанд оролцоход орон нутгийн төсвөөс нийт 4.55 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
	2.4.3.3	Аймгийн ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах	Бага наадамд оролцсон ахмад настны тоо	тоо	2021-2024		2023	140	145	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран Ахмадын спортын бага наадмыг зохион байгуулах удирдамжийг боловсруулж байна.	ХБ
Зорилт	2.4.4	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг 2019 онд 51 хувь байсныг 2024 онд аймгийн нийт хүүхдийн 59 хувьд хүргэнэ.	Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь	Хувь	2021-2024	УТХО 11.9	2023	57	59	Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 9 төрлийн урьдчилан сэргийлэх, нөлөөлөл, хамгааллын хариу үйлчилгээг зохион байгуулж давхардсан тоогоор 5509 хүүхэд буюу нийт 17927 хүүхдийн 37,6%-д хүрч ажиллалаа.	63.7
3.5.1.3	Эрчим хүч хэмнэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хөрөнгийг шийдвэрлэх	Хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн эсэх	тийм-1 үгүй-0	2021-2024		2023	1	1	Эрчим хүч хэмнэлтийн хүрээнд дулаан алдагдлыг багасгах зорилгоор 30, 6-р байрны дээвэр, гадна пасадны засварын угсралтын ажилд гэрээ байгуулан гүйцэтгэж байна.	60
3.6 Тээвэр, логистик										
3.6	Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2024 онд 5386.1 сая төгрөгт хүргэнэ.	Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	сая.төг	2021-2024		2023	5374.6	5386.1	2022 оны аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 5,335.1 сая төгрөг болж өмнөх оноос 61.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.■	70
3.6.1.1	Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах	Холбогдох байгууллагатай хамтарч ажилласан эсэх	тийм-1 үгүй-0	2021-2024		2023	1	1	Дундговь аймаг 2019 оноос эхлэн Говьсүмбэр, Өвөрхангай аймгийн ЗДТГ, МУ-ын Засгийн газар болон Зам тээвэр хөгжлийн яамтай Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам шинээр барих ажлын ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулан батлуулж тус хатуу хучилттай авто замын эхлэлийн үе шатны 17,994.3 сая төгрөг 2024 оны УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдаад байна.	100
3.6.1.2	Мандалговь-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу үүрэн телефоны сүлжээ бий болгох	Үүрэн телефоны сүлжээний тоо	тоо	2022-2024		2023	1	2		ХБ

	3.6.1.3	Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	Хөрөнгийн асуудал шийдвэрлэн хяналт тавьсан эсэх	тийм-1 үгүй-0	2021-2024	2023	1	1	2024 онд ЗТХСайдын багцад Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд нийт 3,959.5 сая төгрөг батлагдсан. ЗТХЯ "Дундговь авто зам" ХХК-тай Мандалговь-Улаанбаатар чиглэлийн А0201 дугаартай нийт 98.2 км авто замын засвар арчилгаанд 954.6 сая, Мандалговь-Даланзадгад чиглэлийн А0202 дугаартай нийт 154.0 км авто замын засвар арчилгаанд 863.7 сая, "Төв азда" ТӨХК-тэй Мандалговь-Улаанбаатар чиглэлийн А0201 дугаартай нийт 153.8 км авто замын засвар арчилгаанд 1,245.7 сая, Өмнөговь аймгийн авто зам хариуцагчтай Мандалговь-Даланзадгад чиглэлийн А0202 дугаартай нийт 151.1 км авто замын засвар арчилгаанд 895.6 сая төгрөгийн гэрээ байгуулж ажил эхлээд байна.	100
4. ЗАСАГАЛЫН БОДЛОГО										
Зорилго	4	Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 65.8 хувьтай байгааг 2024 онд 78.6 хувьтай болгож нэмэгдүүлнэ.	Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин	хувь		2023	75.4	78.6		ХБ
4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ										
Зорилт	4.1.1	Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ.	Тухайн жилд хэрэгжсэн цахим шилжилтийн хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024	2023	90	95	Цахим шилжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газруудын 100 хувь албан бичиг солилцооны дундын систем ДОСХ-д холбогдож, бүх төрийн байгууллагуудад албан бичгээ цахимаар илгээж байна. Сумдын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд албан бичиг солилцооны дундын системд холбогдож, хоорондын албан бичиг солилцоо 100 хувь цахимаар явагдаж байна.	100
Арга хэмжээ	4.1.1.1	"Цахим аймаг- Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024	2023	50	80	Аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсыг шинэчлэн бүх сумдад шинээр цахим хуудастай болгон нийтийн мэдээллийн тухай хуулийн хүрээнд 98 төрлийн мэдээллийг ил болгосноор цахим мэдээллийн ил тод байдал 98,9 хувьд хүрсэн.	100
	4.1.1.2	Сумдыг 4G сүлжээтэй болгох	4G сүлжээтэй болсон сумдын тоо	тоо	2021-2024	2023	10	15		ХБ
	4.1.1.3	Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг улирал бүр зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2021-2024	ОНТ-8.2 сая төгрөг 2023	6000	7000	Баянжаргалан, Дэлгэрцогт, Хулд, Луус зэрэг 6 сумд малчдын болон эмэгтэйчүүдийн уулзалтыг зохион байгуулж, нийт 2400 гаруй иргэд хамрагдсан байна.	34
	4.1.1.4	Төрийн архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хувь	хувь	2021-2024	2023	93.5	95	Тус онд 15 байгууллагын 3441 хадгаламжийн нэгж баримт цахим хэлбэрт шилжүүлэхээс 04 дүгээр сарын байдлаар 8 байгууллагын 704 хадгаламжийн нэгж баримт цахим хэлбэрт шилжүүлээд байна. Энэ нь төрийн архивын хадгаламжийн санд хадгалагдаж байгаа нийт удирдлагын 24.800 гаруй баримтын 94 хувь нь цахимжуулаад байна.	100

	4.1.1.5	Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	Нягтруулсан шүүгээ болон бусад тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024		2023	90	100		ХБ
	4.1.1.6	Багийн Засаг дарга, малын эмч, байгаль хамгаалагч нарыг үе шаттайгаар унаажуулах	Хүлээлгэж өгсөн мотоциклын тоо	тоо	2024	ОНТ 29.3	2023		20	Аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч нарт 2023 онд 6 сумын 7 байгаль хамгаалагч нарт мотоциклыг хүлээлгэн өгсөн.	30/ХБ
	4.1.1.7	Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ" систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгах	Тухайн жилд зөрчилгүй болсон иргэний тоо	тоо	2021-2024		2023	2050	2050	Мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгасан. "Гэрэгэ" киоск төлбөрийн машиныг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлж төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломж бүрдэж, Иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн төрөлтийн бүртгэлд овог, эцэг эхийн нэр, бүртгэлийн дугаар зөрүүтэй бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг анхан шатны журнал бүртгэл иргэдийн гар дээр байгаа бичиг баримтад үндэслэн жагсаалтаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн мэдээллийн санд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан үр дүн гарав.	100
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба											
Зорилго	4.2	Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна.	сахилга, ёс зүйн хариуцлага зөрчлийн бууралт	хувь	2021-2024		2023	7	6		
	4.2.1	Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна.	томилгооны зөрчлийн бууралт	хувь	2021-2024		2023	17.3	13.3		
	4.2.1.1	Төрийн албан хаагчдыг шатлан дэвшүүлэх зарчмыг баримтлах	Тухайн жилд шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	хувь	2021-2024		2023	2	2	Төрийн албаны тухай хууль болон чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн 11 төрийн жинхэнэ албан хаагчийг шатлан дэвших зарчмын дагуу мэргэшсэн тогтвортой байдлыг ханган ажилласан нь нийт төрийн жинхэнэ албан хаагчийн 2.1 хувийг эзэлж байна.	100
	4.2.1.2	Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	тоо	2021-2024	ОНТ 16.8	2023	184	230	Удирдлагын академийн Төрийн албанд анх томилгосон албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 10, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 6, төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч тус тус улсын төсвийн санхүүжилтээр хамруулаад байна. Мөн Төрийн албаны сургууль Удирдлагын академтай хамтран сумдын багийн Засаг дарга нарыг чадваржуулах сургалтыг 2024.03.22,23-ны өдрүүдэд зохион байгуулж 68 багийн Засаг даргыг хамрууллаа.	40
	4.2.1.3	Засгийн газар болон аймгийн захиагаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийх	Тухайн жилд гэрээ байгуулсан оюутны тоо	тоо	2021-2024		2023	30	30	"Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд орон нутгийн захиагаар орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа ШУТИС, Глобал удирдагч их сургууль, Мандах бүртгэл дээд сургуульд суралцаж байгаа төгсөх курсийн 6 оюутантай гэрээ байгуулаад байна.	20

	4.2.1.4	"Нээлттэй-Дунговь" төсөл хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024	2023	80	100	Нээлттэй-Дунговь хөтөлбөрийн төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа болон ТЗЗУ, зураг төсөв боловсруулах, зөвлөх үйлчилгээний зардалд аймгийн төсөвт 200.0 сая төгрөг батлуулж төлөвлөгөөний дагуу зохион байгуулах ажлууд 6 дугаар сарын 8-ны өдрөөс хэрэгжиж эхлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.	30
	4.2.2	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	Шударга байдлын үнэлгээ	хувь	2021-2024	2023	73.5	75	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлига, хүнд сурталгүй "Дунговь авлигагүй хөгжинэ" уриалгыг санаачлан хэрэгжүүлсний үр дүнд Авлигатай тэмцэх газраас 2 жил тутамд хийгддэг төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ 75.8 хувьтай дүгнэгдсэн нь өмнөх үеэс 2.9 функтээр нэмэгдсэн. Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан дүгнэлт/албан бичиг/-ийг аймгийн www.dundgovi.gov.mn сайтыг Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт ХАСУМ хянуулсан 5 дүгнэлтийг байршуулан ил тод нээлттэй сурталчилж шударга байдлыг ханган ажиллаж байна.	100
Арга хэмжээ	4.2.2.1	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2021-2024	2023	90	90	Аймгийн ЗДТГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээтэй төлөвлөн боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, сургалтыг зохион байгуулан ажилласан ба хагас жилийн хэрэгжилтийн биелэлт гаргах хугацаа болоогүй байна.	100
	4.2.2.2	Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах	ЭБАТ-ны сургалт, семинарт хамралтын хувь	хувь	2021-2024	2023	100	100	2023 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны цахим семинар сургалтад төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах салбар эрх бүхий албан тушаалтнуудыг 100 хувь оролцуулан чадавхжуулж, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.	100
	4.2.3	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, суртчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ.	Тухайн жилд эрх зүйн сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь	Хувь	2021-2024	2023	14	15	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгуулах зорилт тавин сумдын "Эрх зүйн хөтөч"-үүдтэй хамтран ажилласны үр дүнд нийт 6415 иргэн буюу 15 хувьд эрх зүйн тусалцаа үйлчилгээ үзүүлээ.	100
	4.2.3.1	Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах	тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо	тоо	2021-2024	2023	3	3	Тус аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нөхцөл байдлаас шалтгаалан иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг эрх зүйн хөтөч нараар дамжуулан сургалтыг зохион байгуулж байна.	100/

	4.2.3.2	Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх	Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан СӨГ-ын шийдвэрлэлтийн өсөлт	хувь	2021-2024		2023	88	89	Хуульчид нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйл ажиллагаа үзүүлэх зорилгоор хууль хяналтын байгууллагууд хамтран "Хуульчийн про боно өдөр-2024" өдөрлөгийн арга хэмжээг ЗДТГ-ын "Говь" танхимд 2024.05.01-ний өдөр зохион байгуулан 450 гаруй хүн хамрагдаж, 119 хүнд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагадагч, шүүгчдэгч, хохирогч нарт өмгөөллийн үйлчилгээг улсын өмгөөлөгчийн зүгээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон прокурор, шүүхийн шатанд 25 хэргийн 25, зөрчлийн 6 хэргийн 6, иргэний 4 хэргийн 4 нийт 35 хэргийн 7135 үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчөөр оролцож үйлчилгээ үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 119 иргэнд үзүүлсэн. Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан санал, өргөдөл, гомдол ирээгүй байна.	100
	4.2.3.3	"Жендэрийн эрх тэгш байдал" тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	тоо	2021-2024		2023	1	1	Жендэрийн харилцан хүндэтгэе аяныг 2024 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулсан. Аянд 12 сум, 14 байгууллага нэгдэж Жендэрийн сургалтад 1037 иргэд, албан хаагч хамрагдаж аянд 1959 иргэн нэгдсэн байна.	100
4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм											
Зорилго:	4.3	Гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2019 онд 86.5 байсныг 2024 онд 90-ээс дээш хувьд хүргэнэ.	Гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувь	хувь	2021-2024		2023	89	90	2024 оны эхний 4 сарын байдлаар нийт 116 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас 70 хэргийг шийдвэрлэж, хэрэг шийдвэрлэлт 60.3 хувьтай байна. Одоо хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 46 хэргийн үлдэгдэлтэй ажиллаж байна.	0
	4.3.1	Гэмт хэргийн гаралт 2018 онд 266 байсныг 2024 онд 10-аас доошгүй хувиар бууруулна.	Бүртгэгдсэн гэмт хэргийн бууралт	тоо	2021-2024		2023	246	240	2024 оны эхний 04 сарын байдлаар нийт 82 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ оны эхний 4 сард бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 19 нэгжээр буюу 18.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100

4.3.1.1	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулан, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт	тоо	2021-2024	2023	48	45	<p>Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас хувь хүн, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор "Архи үгүй амьдрал-Аз жаргал" аяныг 2024 оны 1-7 дугаар сарын хугацаанд зохион байгуулж байна.</p> <p>Аяны хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Мэргэжилтний баг, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар хамтран "Та татгалз-Бид дэмжье", "Та бол онцгой нэгэн" сэдэвт зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, "Говийн хийморь" АА бүлгийн ухаарлын яриа таниулга, "Хувь хүн өөрийгөө олох нь" сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд "Та бол онцгой нэгэн" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 12 иргэн, ахуйн хүрээнд архидан согтуурч, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг 17 нийт 29 иргэнд нэг бүрчилсэн хяналт тавьж ажиллаж, тухайн иргэдтэй 7 хоногт 1-2 удаа уулзалт зохион байгуулан нийт 29 иргэний хаягаар 8 удаа дроноор хяналт тавин, 148 удаа уулзаж ярилцан санамж, сэрэмжлүүлэг хүргэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж ажилласан. Арга хэмжээний хүрээнд 2 иргэнийг ажилд зуучилж, 5 иргэн сайн дураараа архи, согтууруулах ундаанаас татгалзаж, 2 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сард бүртгэгдсэн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 нэгжээр буюу 37.5 хувиар өссөн байна.</p>	70
4.3.1.2	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	2021-2024	2023	13	14	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, "Гэрэлтдэг ертөнц" ТББ-гатай хамтран "Тат татгалз-Бид дэмжье", "Та бол онцгой нэгэн", "Архи үгүй амьдрал-Аз жаргал" зэрэг аян, тусгай арга хэмжээ, "Нэг тэрбумаараа тэмцье-2024", гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, чөлөөт цагаа гэр бүлдээ зориулж, зөв боловсон өнгөрүүлэх, хамтдаа хөгжих, гэр бүлийн орчинд найрсаг, таатай уур амьсгалыг бүрдүүлэх, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор "Хайр дүүрэн гэр бүл" өдөрлөг зэрэг соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсан. Иргэдэд зохион байгуулсан сургалт, мэдээллийн үеэр гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх, хүчирхийллийн хэлбэр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлага, гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх үүрэг, гэр бүлийн зөрөг харилцааны талаар нийт 5 төрлийн зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн 775 иргэнд тараасан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын мэдээг, урьдчилан сэргийлэх зөвлөмжийн хамт "Дундговь амьдрал" сонинд 3 удаа мэдээлэл нийтлүүлсэн.</p>	100

4.3.1.3	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг үе шаттай зохион байгуулах	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бууралт	тоо	2021-2024	2023	11	10	<p>Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн хяналт шалгалтыг 6 удаа зохион байгуулж, согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 122, эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 68 иргэнд торгууль оногдуулж, гарч болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулан ажилласан.</p> <p>Зам тээврийн осол, хэргийг бууруулах чиглэлээр "Мотоцикл ба хамгаалах малгай", "Мэдэгдэл шаардлага "сэдэвт 2 арга хэмжээг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэл, 16 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 860 хүнийг хамруулж, цагдаагийн газрын фэйсбүүк хуудаст постер 8, сэрэмжлүүлэг мэдээлэл 12-г байршуулж, давхардсан тоогоор 28.537 хандалт авсан байна.</p> <p>Энэ оны эхний 4 сарын байдлаар 4 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 42.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	100
4.3.1.4	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, оролцоотой томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх	Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт	хувь	2021-2024	2023	40	45	<p>Цагдаагийн газраас аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 42 аж ахуй нэгж байгууллагатай хамтарч MNS6423:2019 стандартын шаардлага хангасан теле хяналтын камерын системийг суурилуулах ажлыг зохион байгуулах "Хамтран ажиллах гурвалсан гэрээ" байгуулан ажиллаж байна.</p> <p>Тус аймгийн хэмжээнд оны эхний 04 сарын байдлаар энэ төрлийн гэмт хэрэг 11 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 нэгжээр буурсан ба хэргийн илрүүлэлт 45.5 хувьтай байна.</p>	100
4.3.1.5	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах	Мал хулгайлах гэмт хэргийн бууралт	тоо	2021-2024	2023	24	22	<p>Самналт" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, туслах малчин, хөлсөөр ямаа самнаж байгаа иргэдийн судалгаа мэдээлийг авч, дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд малчид, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний 4 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1-эр буюу 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэргийн илрүүлэлт 100 хувьтай байна.</p>	100
4.3.2	Гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 49.4%-тай байсныг 2024 онд 55-аас дээш хувьд хүргэнэ.	Гэмт хэргийн илрүүлэлт	хувь	2021-2024	2023	53	55	<p>Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт эхний 4 сарын байдлаар 52.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6 хувиар өссөн бөгөөд улсын дунджаас 16 хувиар өндөр байна.</p>	100
4.3.2.1	Аймгийн Цагдаагийн газрын автопарк болон алба хаагчдын 25-аас доошгүй хувийн хэт богино долгионы радио холбоог шинэчилж, албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	Радио холбоогоор хангагдсан албан хаагчдын эзлэх хувь	хувь	2021-2024	2023	60	70	<p>Цагдаагийн газрын албан хэрэгцээнд автомашин худалдан авах 100,0 сая төгрөг, алба хаагчдыг радио станц, энгэрийн камераар хангахад зориулж 20 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээд байна.</p>	100

Зорилт	4.3.3	Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ.	Гамшигтай эрсдэлийн бэлэн байдлын хувь	хувь	2021-2024		2023	70	73	Дундговь аймгийн хэмжээнд гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 71,3 хувьтай хэрэгжиж байна.	90
Арга хэмжээ	4.3.3.1	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангах	Утасны эрх сэргээсэн малчидын тоо	тоо	2021-2024		2023	14	14	Дундговь аймгийн "Аса цогцолборын сүлжээ, аюулаас амжиж анхааруулах" мэдээллийн ажлын хүрээнд 15 сумын толгойн сэргийлэх малчдын утасны эрхийг жил бүр сунгадаг. Толгойн сэргийлэх малчид 15 удаагийн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг 3560 иргэнд дамжуулж учирч болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон иргэдийг хамгаалсан.	100
			Сэрэмжлүүлэг мэдээ, зөвлөмж дамжуулсан тоо	тоо	2021-2024		2023	12	14	Аймгийн Онцгой комисс, Засаг даргын тамгын газрын дарга, багийн дарга, сумын хэсгийн төлөөлөгч, толгойн сэргийлэх малчид, 15 сумын малчид нийт 750 иргэнд цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг хагас жилийн байдлаар 16 удаагийн давхардсан тоогоор 3560 иргэдэд мессеж, дуудлага мэдээг дамжуулсан. Мэдээллийг хүргэснээр эрсдэлд өртөх иргэдийн тоон үзүүлэлт 10-15 хувиар буурсан.	100
	4.3.3.2	Гамшгаас хамгаалах ангиллын сургалтанд орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах	Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувь	2021-2024		2023	25	30	Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу орон нутгийн хүн амд гамшгаас хамгаалах тухай мэдлэг олгох, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны хагас жилийн байдлаар Дундговь аймгийн хэмжээнд 21 удаагийн сургалтад 3552 иргэнийг хамруулан, нийт иргэдийн 7.4 хувийг хамруулсан.	50
	4.3.3.3	Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах	Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо	тоо	2021-2024	ОН-4.5	2023	6	6	Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Дундговь аймгийн Адаацаг, Хулд, луус суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Гурвансайхан суманд команд штабын сургууль тус тус зохион байгуулж бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан.	70
	4.3.3.4	Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслээр хангах	Ажлын байр, хүний нөөцийн нөхөн хангалтын хувь	Хувь	2021-2024		2023	80	90	Хулд сумын Эрэн хайх аврах бүлгийн хүний нөөцийн нөхөн хангалтын хувь 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар 87 хувьтай үйл ажиллагаагаа явуулж байна.	100
Техник хэрэгсэл, багажын хангалтын хувь			Хувь	2021-2024		2023	80	85	Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд Хулд сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн үйл ажиллагаанд тус сумын Засаг даргын нөөц хөрөнгөөр Хено маркийн 1,5 тн усны савтай, гал унтраах нацостай, гал унтраах жижиг оврын автомашиныг 6,75 сая төгрөгөөр шийдвэрлүүлсэн. 2024 оны байдлаар Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газраас техник хэрэгслийн дэмжлэг авах үйл ажиллагаа гүйцэтгэлийн шатан дээрээ явагдаж байна.	70	
4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого											

Зорилт	4.4.1	БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 онд 500 сая төгрөг байсныг 2024 онд 900 сая.төгрөгт хүргэнэ.	Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Сая.төг	2021-2024	109,1 сая	2023	800.0	900.0	2024 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ийн Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл, Америкийн Нэгдсэн Улсын олон улсын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэй Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төсөл, БНСУ-ын "Экспорт, импорт" банкны Аймгийн төвийн "Дулааны станц барих төсөл", Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилттэй гэр сургууль хөтөлбөр, Франц Улсын сайн дурын байгууллагын Ариун цэврийн байгууламжийн төсөл, БНСУ-ын "COVA" олон улсын байгууллагын Ундны цэвэр ус төсөл, нийт 6 гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөр хэрэгжин 200 сая төгрөгийн санхүүжилт хийгдэв.	22
Арга хэмжээ	4.4.1.1	БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай гадаад хамтын ажиллагааны хүрээнд тусгасан ажлуудыг шат дараалалтайгаар зохион байгуулах	Хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын тоо	тоо	2021-2024	ОНТ 29,1 сая	2023	5	7	Япон Улсын Эхиме мужийн Сейёо хотод хамтын ажиллагааг өргөжүүлэх албан айлчлал хийв. Уулзалтын үр дүнд соёлын салбарын хамтын ажиллагааг эхлүүлэн Дундговь аймгийн уран бүтээлчдийн тоглолтыг Сейёо хотод зохион байгуулах, сурагч хүүхдүүдийн солилцооны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх хэлэлцээрт хүрч арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж болон Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хотын удирдлагуудыг 8,9 дүгээр сард орон нутагт айлчлах бэлтгэх ажлыг ханган Уламжлалт анагаах ухааны хамтарсан эрүүл мэндийн үзлэг, ингэн сүүний фермийн туршлага дээр үндэслэн үйлдвэр байгуулах зэрэг ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын Зүүн Хойд Азийн Нутгийн захиргааны холбоо/NEAR/-нд 1 төрийн хаагчийг олон улсын туршлага судлах хөтөлбөрт хамруулав. Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөрийн бие даах институттай хамтын ажиллагааг эхлүүлж амжиргааны түвшин доогуур ажилгүй иргэдийг ажилд зуулчлах, хөдөлмөрлөх боломжийг бүрдүүлэх талаар санамж бичиг байгуулав. Нийт 3 арга хэмжээг зохион байгуулж, 3 арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж байна.	86
	4.4.1.2	БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуаянг хоттой байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг ханган жилд 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах	Санамж бичгийн хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024		2023	70	80	Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуаян хотын Дахам төрийн бус байгууллагатай хамтран Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан солонгос хэлний танхим байгуулсан. Баяннуур хоттой Уламжлалт анагаах ухааны хамтарсан үзлэг хийхээр бэлтгэл ажил хангаж байна.	70/ХБ
	4.4.1.3	Төрийн албан хаагчдыг чадавжуулах зорилгоор Гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулах	Тухайн жилд туршлага судлах албан хаагчдын тоо	тоо	2021-2024		2023	30	40	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хот болон Санья, Гуанжоу хотод 23, Япон Улсад 8, Бүгд Найрамдах Солонгос Улсад 1, нийт 32 төрийн албан хаагчийг гадаадад туршлага судлах хөтөлбөрт хамруулсан.	80
	4.4.1.4	Улаанбаатар хот дахь ОШУСТ-тэй хамтран жил бүр ОХУ-ийн ЗГ-ын тэтгэлэгт Хөтөлбөрт багш, сурагчдыг хамруулан ажиллах	Оролцсон багш, сурагчдын тоо	Тоо	2021-2024		2023	8	10		ХБ
4.5 Батлан хамгаалах											
Зорилт	4.5.1	Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамж 2020 онд 80 хувь байсныг 2024 онд 88 хувьд хүргэнэ.	Цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөлтийн онол, дадлагын бэлтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	86	88	Дайчилгааны тухай хууль 18.1.1, 1.2-д заасны дагуу 2023 оны цэргийн бүртгэлийн үеэр сумдын тоо бүртгэл явуулах комисс сумдуудын цэргийн дайчилгааны даалгавар болон орон нутгийн хамгаалалтын отрядын бүрэлдэхүүний тодотгол хийж нас барсан, шилжсэн, тодорхойгүй шалтгаанаар алга болсон зэрэг иргэдийг шинээр томилгоожуулан даалгаваржуулсан.	100

Арга хэмжээ	4.5.1.1	Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчилан таниулах	Сургалтанд хамрагдсан сурагчдын хамрагдалтын хувь	хувь	2021-2024		2023	90	100	Монгол улсад генерал цол олгож эхэлсний 80 жилийн ой, "Монгол генералын өдөр"-ыг тэмдэглэх, хүүхэд залуучуудад "Эх оронч" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор цэргийн дээд цолыг сурталчлах, нутгаас төрөн гарсан генералуудад хүндэтгэл үзүүлэх, аймгийн Засаг даргын ивээл дор Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, ЕБС сурагчдад тус тус 04 дүгээр сарын 29-ний өдөр Мандалговь хотноо зохион байгуулсан.	100
	4.5.1.2	Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилэн нөөцийг бүрдүүлэх	Дайчилгааны бэлэн байдлын нөөцийн хувь	хувь	2021-2024		2023	100	100	2024 онд Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг 80 хүнтэйгээр хээрийн дадлагаар зохион байгуулж онол, дадлагын бэлтгэл, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын зэргийг дээшлүүлнэ.	30/ХБ
	4.5.1.3	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах.	тухайн жилд зохион байгуулах сургалтын тоо	тоо	2021-2024		2023	2	2		ХБ
	4.5.1.4	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах	Бүтээн байгуулалтын ажилд оролцсон иргэдийн тоо	тоо	2021-2024		2023	30	30	Цэргийн албаны тухай хууль, ЗГ-ын 2018 оны 80 дугаар тогтоолын тооны хязгаарын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч 30 халж, шинээр 20 иргэнийг элсүүлэн авч нийт 35 иргэнтэйгээр журмыг мөрдүүлэн ажиллуулж байна. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 20 иргэдийн сургалтыг 2024 оны 05.20-06.04-ны дуустал явуулж байна. Эдгээр 20 алба хаагчдыг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулаа.	100
5.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГ											
5.1 Ногоон хөгжил											
Зорилго	5.1	Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.	Ногоон байгууламжийн хэмжээ	га	2021-2024	ОНТ 25.0 Хувийн хэвшил 9.0	2023	392	403	Улс, орон нутгийн хөрөнгөөр 2021-2023 онд ойн зурвас 31 га, зам дагуу 25.9 га нийт 56.9 га талбайд мод тарьж ногоон байгууламжийн хэмжээ 425,4 га байсныг 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 428,3 га-д хүрэв.	100
			Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ өссөн дүнгээр	га	2021-2024	хувийн хэвшлийн 35.6	2023	139.64	159.64	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газар 613.9 га түүнд ногдох нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 2020 онд 51 га буюу 8.3 хувийг эзлэж байсан. 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 157.54 га-д буюу 29 хувьд хүрэв.	
			Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь өссөн дүнгээр	хувь	2021-2024		2023	36.9	37	Баянжаргалан, Хулд, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Адаацаг, Эрдэнэдалай, Гурвансайхан зэрэг 7 сумд 9 цэвэршүүлэх төхөөрөмж шинээр суурилуулснаар төв суурин газрын хүн амын 42 хувь нь шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан. 2024 онд Өндөршил, Дэлгэрцогт, Луус суманд нийт 3 ус хангамжийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулна.	
			Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ	тн	2021-2024	ОНТ 3.0 Хувийн хэвшил 3.0	2023	26	46	2024 оны эхний хагас жилийн байдлаар 68 тонн дахивар нөөц тушааснаар нийт 311 тонн дахивар хог хаягдлыг тушаасан.	
	5.1.1	Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 2024 он гэхэд 4 хувиар бууруулна.	Төв суурин газрын орчны бохирдлын түвшний бууралтын хувь	хувь	2021-2024		2023	4	5	Төв суурин газрын орчны бохирдлыг бохирдуулагч эх үүсвэрийн бууралтын хувиар дундажлан тооцдог. Аймгийн хэмжээнд 24 нүхэн жорлонг буулгаж, нам даралтын уурын зуухны тоо 7-оор буурч, 10 төвлөрсөн халаалтын зууханд утгат шүүлтүүр суурилуулж төв суурин газрын орчны бохирдлын хэмжээ 4.2 хувиар багассан үзүүлэлттэй байна.	70

5.1.1.1	Агаарт агуулагдаж байгаа тоос тоосонцорыг хэмжих зөврийн багажтай болж, 3 төрлийн бодисыг бүрэн хэмждэг болох	Агаарын чанарын индексийн түвшин	индекс	2021-2024		2023	100>	100>	Мандалговь хотын агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нарийн ширхэгт тоосонцор /pm2.5/-ыг тогтмол хэмжиж байна.Агаарын бохирдлыг агаарын чанарын индексээр үнэлэхэд эхний хагас жилийн байдлаар 72 буюу хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай байна.	100
5.1.1.2	Утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх	утаа бага ялгаруулдаг зуухны тоо	тоо	2021-2024		2023	4	5	2022 онд БОАЖЯам "Кан Мэй Хуан Бао" ХХК-тай гэрээ байгуулан аймгийн 10 нам даралтын зууханд утаа шүүгч, "Ригал инженеринг" ХХК-тай гэрээ байгуулан 3 ААН-гийн 8 зууханд угат шүүлтүүр тус тус байршуулсан. Гэрээний дагуу 2023 онд 10 нам даралтын зууханд суурилуулсан ажлыг улсын комисс хүлээж авсан. Нийт 18 зууханд утаа шүүгч суурилуулагдаж агаарын бохирдлыг 20% бууруулах боломж бүрдсэн.	100
5.1.1.3	Төв суурин газрын гэр хорооллын сайжруулсан зуухны тоог нэмэгдүүлэх	Сайжруулсан зуухны өсөлтийн хувь	хувь	202-2024		2023		9	2023 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын дүнгээр аймгийн төвийн гэр хорооллын айл өрхийн 16.7 хувь сайжруулсан зуухаар хангагдсан. Утаа бага ялгаруулдаг болон сайжруулсан 3 төрлийн зуухны мэдээллийг цахимаар иргэдэд сурталчилж, 2500 хүнд хүргэсэн. НҮБ-ын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй "Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП төсөл хэрэгжиж одоогоор 64 багц олгогдсоноор 64 айл өрх, 1 аж ахуйн нэгж утаагүй технологи "ЧИП" багцийг хэрэглэж байна. 2024 онд шинээр 100 өрхийг чил багцыг төсөлд хамруулахаар төлөвлөж, орон нутгийн төсөвт 200.0 сая төгрөг баталсан.	100/ХБ
5.1.1.4	Гэр хороолол болон аялал жуулчлал, уул уурхайн бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэх	Эко ариун цэврийн байгууламжийн тоо	тоо	2021-2024	ОНТ 3.0 Хувийн хэвшил 9.0	2023	35	40	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Эко жорлон" арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 хүнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн "Эко жорлон" үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлуулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд шинээр стандартын шаардлага хангасан 5 ариун цэврийн байгууламж нэмэгдэж аймгийн хэмжээнд эко ариун цэврийн байгууламжийн тоо 179-д хүрэв	100
5.1.2	Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2024 он гэхэд 46 тонн дахивар хогийг нийлүүлнэ.	Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ	тн	2021-2024	ОНТ 35.40	2023	11	20	Сайнцагаан, Адаацаг, Говь-утгаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайхан-овоо, Эрдэнэдалай сумдад дахивар авах цэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж 2020-2023 онуудад нийт 243 тн дахивар нөөц цуглуулж Улаанбаатар хот дахь дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушаасан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 68 тонн дахивар нөөц тушааснаар нийт 311 тонн дахивар хог хаягдлыг тушаасан.	100

	5.1.2.1	Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах	Шууж булшилсан талбайн хэмжээ	га	2021-2024	ОНТ 5.0 Хувийн хэвшил 80.0	2023	14	16	Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй асгасан хог болон төвлөрсөн хогийн цэгийг Эрдэнэдалай 3 га, Луус 4 га, Баянжаргалан 0,2 га, Говь-Угтаал 5 га, Дэрэн 1 га, Гурвансайхан 5 га нийт 6 сум 18.2 га талбайг шууж булшилсан. Үүнээс төвлөрсөн хогийн цэгийн талбайн Дэлгэрцогт суманд 0.3 га талбайг шууж булшилж талбайн хэмжээг 0,3 га-аар багасгаж 128.8 га-аас 128.5 га болж буурсан.	70
	5.1.2.2	Аймгийн төвд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх	Хогийн савны нэмэгдүүлсэн тоо	тоо	2021-2024	ОНТ 36.0	2023	40	45	"ААН байгууллага 1, сургуульд 2, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Аймгийн төвийн нийтийн орон сууцны гадна талбайд 9 ангилан ялгах хогийн сав байршуулж аймгийн төвийн ангилан ялгах хогийн сав 81 байсан нь 93 болж нэмэгдэв. Аймгийн хэмжээнд Луус суманд 2, Сайнцагаан суманд 12 ангилан ялгах хогийн сав нэмэгдэж 311 байсан нь 325 болж нэмэгдсэн.	100
Зорилт	5.1.3	Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 26.5 байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	2021-2024		2023	29	30	Баянжаргалан, Хулд, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Адаацаг, Эрдэнэдалай, Гурвансайхан зэрэг 7 суманд 9 цэвэршүүлэх төхөөрөмж шинээр суурилуулснаар төв суурин газрын хүн амын 42 хувь нь шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан. 2024 онд Өндөршил, Дэлгэрцогт, Луус суманд нийт 3 ус хангамжийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулна.	30
	5.1.3.1	Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах	Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо	тоо	2021-2024		2023	2	2	2024 онд Өндөршил, Дэлгэрцогт, Луус суманд нийт 3 ус хангамжийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын даалгавар боловсруулж ХБТХОХэлтэст хүргүүлэв.	30
	5.1.3.2	Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хамгаалалтын бүс тогтоосон булгийн тоо	тоо	2021-2024	ОНТ 6.0	2023	30	30	2024 онд Өлзийт, Сайнцагаан суманд нийт 26 булгийн онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэв.	100
	5.1.3.3	Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	Хашсан булгийн тоо	тоо	2021-2024		2023	62	65	2024 онд Өлзийт суманд 2, Сайхан-Овоо суманд 1, нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын даалгавар боловсруулж ХБТХОХэлтэст хүргүүлэв.	30
Зорилт	5.1.4	Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 413.4 га-д хүргэнэ.	Ногоон байгууламжийн хэмжээ	га	2021-2024	ОНТ 25.0 Хувийн хэвшил 9.0	2023	392.4	403.4	Улс, орон нутгийн хөрөнгөөр 2021-2023 онд ойн зурвас 31 га, зам дагуу 25.9 га нийт 56.9 га талбайд мод тарьж ногоон байгууламжийн хэмжээ 425,4 га байсныг 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 428,3 га-д хүрэв.	100
Арга хэмжээ	5.1.4.1	Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгох	Ногоон байгууламжийн хэмжээ	га	2021-2024	ОНТ 25.0	2023	20	30	"Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу 6 байршилд гудамж бүрийг төрөлжүүлэн цэцэрлэгжүүлэх зорилгоор нарс, гүйлс, агч, голт бор, улиас, хайлаас, далан хальс зэрэг 8 төрлийн 1644 мод, сөөг тарьж усалгаа, арчилгаа хийж байна.	100
	5.1.4.2	Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах	Тухайн жилд байгуулсан ойн зурвасын талбайн хэмжээ	га	2021-2024	Хувийн хэвшил 9.0	2023	1	1	Сайхан-Овоо сумын Төгрөгийн хийдэд 2 га-д 1200 мод тарьж, усны нөөцийн сав, усалтын систем суурилуулав.	100
Зорилт	5.1.5	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувьд хүргэнэ.	Нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь /өссөн дүнгээр/	хувь	2021-2024	хувийн хэвшлийн 35.6	2023	20.5	24.6	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газар 613.9 га түүнд ногдох нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 2020 онд 51 га буюу 8.3 хувийг эзлэж байсан. 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 157.54 га-д буюу 29 хувьд хүрэв.	100

Арга хэмжээ	5.1.5.1	Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэх	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га	га	2021-2024	хувийн хэвшлийн 33.6	2023	129.6	154.6	Аймгийн 3 сумын нутаг дэвсгэрийн 5 байршилд уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгж ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4.87 га, хайгуулын үйл ажиллагаанаас эвдэрсэн 0.09 га, эзэнгүй эвдэрч орхигдсон 4.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 157.34 га-д хүрсэн.	100
	5.1.5.2	Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэх	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га	га	2021-2024	хувийн хэвшлийн 2.0	2023	21	26	2023 онд биологийн нөхөн сэргээлт 26.52 га-д хүрсэн ба 2024 онд Дэлгэрхангай суманд 0.2 га талбайд хийгдсэнээр нийт нөхөн сэргээлтийн хэмжээ 26.72 га-д хүрэв.	100
Зорилт	5.1.6	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ.	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	Хувь	2021-2024		2023	33.1	33.8	Өлзийт сумын "Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга", Адаацаг сумын "Сүм хөх бүрд" улсын тусгай хамгаалалтад авхуулахаар сум, аймгийн тогтоол гаргаж холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Ингэснээр улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ аймгийн нийт газар нутгийн 27 хувиас 28.9 хувь болж нэмэгдүүлж улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 5.7 хувиас 10.8 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.	30
	5.1.6.1	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах	орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	хувь	2021-2024		2023	22.9	23.6	Говь-Угтаал сумын Шарангад, Номгон, Талт толгой орчмын газруудыг сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар холбогдох материалыг боловсруулан ажиллаж байна. Ингэснээр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ аймгийн нийт газар нутгийн 23.2 хувиас 23.6 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлж ажиллаж байна.	30
6. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил											
Зорилго	6.1.	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцаар 2020 онд 108 өрхийг хангаснаас 2024 онд 208 өрхийг нэмж хамруулна.	Хамрагдсан өрхийн тоо	тоо	2021-2024		2023	268	316		ХБ
Зорилт	6.1.1	Иргэдийн оролцоотой "Шинэ сум" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд бүтэцтэй сум 2020 онд 2 байсныг 2024 онд 3-аар нэмэгдүүлнэ.	Тухайн жилд дэд бүтэц нь шийдэгдсэн сум	тоо	2021-2024		2023	1		Луус сумын "Шинэ сум" төсөвт УТХО-аар нийт 3,995.0 сая төгрөгийн төсөвт өргөтгөлтэйгээр 2022-2025 онд хэрэгжихээр батлагдсан.	ХБ
	6.1.1.1	Сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох	Тухайн жилд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумдын тоо	тоо	2021-2024		2023	2	2	2024 оны аймгийн төсөвт Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт 28.4 сая сая төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэгч Ланд Овнер ХХК-ийн ажлын удааширлаас хамаарч хойшлогодод байна. Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авсанаар Дундговь аймгийн 15 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох юм.	30

Арга хэмжээ	6.1.1.2	Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх	тийм-1 үгүй-0	2021-2024	2023	1	1	Өмнөх онд Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авсанаар тус хорооллыг дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж эхлээд байна. Хаус хороолол төлөвлөсөн нийт 8 га талбайд цэвэр бохир, ус, халаалтанд холбогдсон, хашаа, граштай орчин үеийн шийдэл бүхий 119 амины орон сууц байх юм. 2024 оны аймгийн ОНХС болон ОНХО-аар тус хорооллын гадна бохир усны шугамын ажилд 208.9 сая, гадна цахилгаан хангамж, дэд станц байгуулах ажилд 89.0 сая нийт 297.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Мөн Сайнцагаан сумын айраг баг, Адаацаг сумын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих ажилд нийт 498.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсанаар ойролцоогоор 1000 гаруй өрхүүд өмчилж авсан газартаа амьдрах орчин бүрдэж байна.	100
	6.1.1.3	Сумдад орон сууцны барилгыг ашиглалтад оруулах	Тухайн жилд ашиглалтад орсон орон сууцны тоо	тоо	2021-2024	2023	3	3	2024 онд Өндөршил сум ОНХС-ийн хөрөнгөөр 4 айлын сууц барихаар 429.2 сая, Гурвансайхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 12 айлын орон сууц барихаар 900.0 сая төгрөг батлан зураг төсөө боловсруулж байна. Эрдэнэдалай суманд хувийн хэвшлийн хөрөнгөөр 12 айлын орон сууц барихаар төлөвлөн зураг төсвийн ажил хийгдэж байна.	60
	6.1.1.4	Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлын үргэжлүүлэх	Ажлын гүйцэтгэлийн хувь	хувь	2024	2023	-	100	Аймгийн төвийн 6,4 км үерийн хамгаалалтын далан байгууламжийн ажлын зураг төсвийг шинэчлэх хөрөнгийг Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад батлуулсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн "Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай" 2023/02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	30
	6.1.1.5	Цагаандэлгэр сумын ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах	Ажлын гүйцэтгэлийн хувь	хувь	2024	2023		100	2024 онд УТХО-д "Цагаандэлгэр сумын халуус ус, үйлчилгээний төвийн барилга" ажлын төсөвт өртөг нэмэгдэж батлагдсантай холбогдуулан тус ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Одда тайж" ХХК-тай 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан БХБЯ/201802067 тоот гэрээнд заасан 237.3 сая төгрөг гэсэн үнийн дүнг 205.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж гэрээний нийт дүнг 443.0 сая төгрөг болгон баталж 2024 оны 09 сарын 30-ны өдөр барилгыг ашиглалтад оруулсан байхаар харилцан тохиролцож ажил эхлүүлээд байна. Ажлын гүйцэтгэл 30.0 хувьтай байна.	30
	6.1.1.6	Сумдын өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлэх	Шийдвэрлэсэн маргааны тоо	тоо	2021-2024	2023	28	36	2020 оны судалгаагаар сумдын хилийн цэсийн гадна олгосон өвөлжөө, хаваржааны газрын маргаан 71 бүртгэгдсэн байсан. 2021-2024 оны хооронд маргаантай нийт 94 өвөлжөө, хаваржааны газрыг сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган холбогдох сумдын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн.	100
Зорилт	6.1.2	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо 2020 онд 3878 байсныг 2024 онд 4750 болгон нэмэгдүүлнэ.	Тухайн жилд хамрагдсан иргэдийн тоо	тоо	2021-2024	2023	4532	4750		ХБ

	6.1.2.1	ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх	Тухайн жилд байршуулсан мэдээллийн тоо	тоо	2021-2024		2023	12	12	<p>ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний явц, хүлээн авсан тухай мэдээг аймгийн веб сайт болон https://onhs.mof.gov.mn/ сайт, захиалагчийн хяналт гүйцэтгэж буй аймгийн ГХБХБГ-аар сайтаар нийт 11 удаа мэдээллээ. Шилэн хяналтын цахим системд бүртгэж, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тухай бүр мэдээлж, тайлагнагдаж байна. Аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2024 онд аймгийн ОНХС-ийн нийт 7,531.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулан хэрэгжүүлж байна. Аймгийн сайтад 2023 оны ОНХО болон УТХО-ийн төлөвлөлт гүйцэтгэл, хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг 2 удаа, сум бүр өөрийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвийн хүрээний мэдээллээ tender.gov.mn болон сумынхаа сайтад тухай бүр байршуулан мэдээлж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 18 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн нээлттэй ил тод цахимаар зарлан гэрээ байгуулж, 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаагаа зарлагдсан байна.</p>	100
	6.1.2.2	Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг onhs.mof.gov.mn сайтад тухай бүр мэдээлэх	Хэрэгжилтийн хувь	хувь	2021-2024		2023	100	100	Орон нутгийн хөгжлийн сангийн цахим системд 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөг оруулаад байна.	70